# МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1992 оны 5 дугаар сарын 4-ний өдөр

Улаанбаатар хот

## МОНГОЛ УЛСЫН ИРГЭНИЙ ЦЭРГИЙН ҮҮРГИЙН БОЛОН ЦЭРГИЙН АЛБАН ХААГЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ

(хэсэгчлэн авав)

### 3 дугаар зүйл. Цэргийн алба

1. Цэргийн алба нь төрийн албаны онцлог төрөл бөгөөд цэргийн жинхэнэ болон бэлтгэл албанаас бүрдэнэ.

2. Монгол Улсын иргэн Зэвсэгт хүчний бүрэлдэхүүнд цэргийн үүрэг гүйцэтгэхийг цэргийн жинхэнэ алба гэнэ.
**/Энэ хэсэгт 1993 оны 10 дугаар сарын 21, 2006 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн хуулиартус тус өөрчлөлт орсон/**

Цэргийн жинхэнэ алба нь байлдагч, түрүүчийн алба, ахлагчийн болон офицерийн албанаас бүрдэнэ. Харин цэрэгт бүртгэлтэй мэргэжил бүхий эмэгтэйчүүд сайн дураараа офицер, ахлагчийн албыг хуулийн дагуу хааж болно.

3. Энэ хуульд заасан бэлтгэл албаны насны эрэгтэйчүүд, цэрэгт бүртгэлтэй мэргэжил бүхий эмэгтэйчүүд цэргийн тоо бүртгэлд байж дайчилгааны сургууль, цугларалтаар болон хууль тогтоомжид заасан цэргийн албаны бусад үүрэг гүйцэтгэхийг цэргийн бэлтгэл алба гэнэ. Цэргийн бэлтгэл алба нь нэг, хоёрдугаар зэргийн бэлтгэл үүрэгтний албанаас бүрдэнэ.

### 4 дүгээр зүйл. Цэргийн албан хаагч, цэргийн үүрэгтэн

1. Цэргийн жинхэнэ алба хааж байгаа иргэнийг цэргийн албан хаагч гэнэ.

2. Цэргийн бэлтгэл албанд байгаа иргэнийг цэргийн үүрэгтэн гэнэ.

Цэргийн жинхэнэ алба хаасан байлдагч, түрүүч, ахлагч, офицерийг нэгдүгээр зэргийн цэргийн үүрэгтэн гэнэ.

Бэлтгэлд байгаа цэргийн алба хаагаагүй эрэгтэйчүүд, мөн цэрэгт бүртгэлтэй мэргэжил бүхий эмэгтэйчүүдийг хоёрдугаар зэргийн цэргийн үүрэгтэн гэнэ.

### 7 дугаар зүйл. Цэргийн албан тушаал, цол

1. Дээд офицерын албан тушаалын ангилал, цэргийн цолны зэрэглэлийг Монгол Улсын Ерөнхийлөгч, цэргийн бусад албан хаагчийнхыг батлан хамгаалах болон хууль зүй, дотоод хэргийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.

**/Энэ хэсэгт 2006 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн хуулиар нэмэлт орсон/**

2. Цэргийн албан хаагч, нэгдүгээр зэргийн бэлтгэл үүрэгтэн цэргийн цолтой байна. Цэргийн цолыг Монгол Улсын хуулиар бий болгож, олгох, хэрэглэх, бууруулах, хураан авах журмыг Монгол Улсын Ерөнхийлөгч тогтооно.

**/Энэ хэсэгт 2006 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн хуулиар нэмэлт орсон/**

### 8 дугаар зүйл. Цэргийн албан хаагч, цэргийн үүрэгтний дүрэмт хувцас, цолны болон ялгах тэмдэг

1. Цэргийн албан хаагч цэргийн жинхэнэ алба хааж байхдаа, цэргийн үүрэгтэн дайчилгааны сургууль, цугларалтад оролцох үедээ дүрэмт хувцас, цолны болон ялгах тэмдэг хэрэглэнэ.

Цэргийн дүрэмт хувцас, цолны болон ялгах тэмдгийн загварыг Монгол Улсын Ерөнхийлөгч батална.

2. Цэргийн бэлтгэл үүрэгтэнг дайчилгааны сургууль, цугларалтад оролцох үед нь нэг удаа цэргийн дүрэмт хувцас, цолны болон ялгах тэмдгээр хангах үүргийг цэргийн мэргэжлийн удирдлагын төв байгууллага хүлээнэ.

**/Энэ хэсэгт 1997 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/.**

Цэргийн бэлтгэл үүрэгтэн олгосон дүрэмт хувцсыг дайчилгааны сургууль, цугларалтаар хэрэглэж нас хэтэрч бэлтгэл албанаас чөлөөлөгдөх хүртлээ хадгална. Хэрэв үрэгдүүлбэл зохих үнээр нь нөхөн олгоно.

### 12 дугаар зүйл. Тайван цагт цэргийн жинхэнэ албанд татахаас түр чөлөөлөх

5. Монгол Улсын 18-25 насны, цэргийн хоёрдугаар зэргийн бэлтгэл үүрэг бүхий иргэн шашин шүтлэг-ёс зүйн болон энэ хуульд заасан бусад шалтгаанаар цэргийн албыг дүйцүүлэн хааж болно. Цэргийн албыг дүйцүүлэн хаах хүсэлтэй иргэн онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын аврах анги, отряд, салбар Хилийн цэрэгт туслах хүчин болон хүмүүнлэгийн бусад байгууллагад алба

хаана. Уг албыг хаах хугацаа 24 сар байна. Гамшгаас хамгаалах ажиллагааны хойшлуулшгүй арга хэмжээ, улсын хил хамгаалалтын зайлшгүй шаардлагыг харгалзан Засгийн газар энэхүү хугацааг 3 хүртэл сараар сунгаж болно.

**/Энэ хэсэгт 2006 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн хуулиар нэмэлт орсон/**

Цэргийн албыг дүйцүүлэн хаах журам, алба хаах иргэний тооны дээд хязгаарыг Засгийн газар тогтооно.

**/Энэ хэсгийг 1997 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн хуулиар нэмсэн ба 2005 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн хуулиар 2, 4 дэх өгүүлбэрт тус тус өөрчлөлт орсон/**

8. Байлдагч, түрүүчийн алба хаах насны дээд хязгаарт хүрсэн цэргийн алба хаагаагүй иргэн хуулиар тогтоосон хугацаат цэргийн албыг биеэр хаагаагүйн төлөө мөнгөн төлбөрийн хэлбэрээр цэргийн дүйцүүлэх албыг орлуулан хаана. Уг албыг иргэн мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах болзлыг Улсын Их Хурал батална. Мөнгөн төлбөрийн хэмжээг Засгийн газар жил бүр тогтооно. Мөнгөн төлбөрийн орлогын 50 хүртэлх хувийг орон нутгийн төсөвт, үлдсэнийг улсын төсөвт төвлөрүүлэн батлан хамгаалах зорилгод зарцуулна.
**/Энэ хэсгийг 1997 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн хуулиар нэмсэн ба хоёр дахь өгүүлбэрийг 2000 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан ба 2006 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/.**

## Цэргийн жинхэнэ алба

### 13 дугаар зүйл. Цэргийн жинхэнэ алба хаах насны дээд хязгаар

1. Цэргийн албан хаагч нь:

1/ байлдагч, түрүүчийн албыг: -хугацаат цэрэг 27 нас хүртэл; -гэрээт цэрэг 31 нас хүртэл;
*/Энэ заалтад 2006 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/*
2/ ахлагчийн албыг 45 нас хүртэл;
3/ офицерын албыг:
-дунд офицер 45 нас хүртэл;
-ахлах офицер 50 нас хүртэл;
-дээд офицер 55 нас хүртэл тус тус хааж болно.

Эмэгтэйчүүд ахлагч, офицерын албыг цэргийн цол харгалзахгүйгээр 45 нас хүртэл хааж болно.

2. Энэ зүйлийн 1-д заасан насны дээд хязгаарт хүрсэн цэргийн өндөр мэргэжил, дадлага сайтай зарим офицер, ахлагчийн

цэргийн жинхэнэ алба хаах хугацааг батлан хамгаалах болон хууль зүй, дотоод хэргийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрээр 5 хүртэл жил сунгаж болно.

**/Энэ хэсэгт 2006 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн хуулиар нэмэлт орсон/**

## 14 дүгээр зүйл. Байлдагч, түрүүчийн алба

**/Энэ зүйлийн нэрийг 1997 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/**

1. Байлдагч, түрүүчийн алба нь хугацаат цэргийн алба, гэрээт цэргийн албанаас бүрдэнэ. Хугацаат цэргийн алба хаах хугацаа 12 сар, гэрээт цэргийн алба хаах анхны хугацаа 24 сар байх бөгөөд гэрээний хугацааг цаашид 31 нас хүртэл үргэлжлүүлэн сунгаж болно.

**/Энэ хэсэгт 2006 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/**

Хугацаат болон гэрээт цэргийн албаны байлдагч нь байлдагч, ахлах байлдагч, түрүүч нь дэд түрүүч, түрүүч, ахлах түрүүч цолтой байна.

Иргэн цэргийн албыг сайн дурын үндсэн дээр гэрээгээр хаах журмыг Засгийн газар тогтооно.

**/Энэ хэсгийг 1997 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/.**

2. Монгол Улсын Ерөнхийлөгч онцгой нөхцөл бий болсон үед хугацаат албаны байлдагч, түрүүчийн цэргийн алба хаах хугацааг гурав хүртэл сарын хугацаагаар сунгаж болно.

**/Энэ хэсэгт 1997 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн хуулиар нэмэлт орсон/.**

**3. /Энэ хэсэгт 1997 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн хуулиар нэмэлт орсон ба 2002 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар хассан/.**

3. Хугацаат албаны байлдагч, түрүүчийн цэргийн алба хааж эхэлсэн хугацааг тэднийг цэрэг татлагын байрнаас анги, байгууллагад хуваарилсан өдрөөс тооцно.

**/Энэ хэсэгт 1997 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн хуулиар нэмэлт орсон ба дугаарыг 2002 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчилсөн/.**

4. Байлдагч, түрүүчийн цэргийн алба хааж дуусгасан хугацааг тэднийг бэлтгэлээр халах тухай ангийн захирагчийн тушаал гарсан өдрөөс тооцно.

**/Энэ хэсгийн дугаарыг 2002 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчилсөн/**

## 17 дугаар зүйл. Цэргийн сургуулийн сонсогч

1. Цэргийн сургуульд суралцаж байгаа байлдагч, түрүүч, ахлагч, офицерыг сонсогч гэнэ.

Цэргийн сургуульд 17 нас хүрсэн Монгол Улсын иргэнийг сонсогчоор элсүүлэн суралцуулж болно. Сонсогчийн цэргийн сургуульд суралцсан хугацааг цэргийн жинхэнэ алба хаасан хугацаанд тооцно.
**/Энэ хэсэгт 1997 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/.**

## 18 дугаар зүйл. Ахлагчийн алба

1. Цэрэгт бүртгэлтэй мэргэжил бүхий иргэн сайн дураараа ахлагчийн албан тушаалд гэрээгээр цэргийн жинхэнэ алба хаахыг ахлагчийн алба гэнэ.

Гэрээний анхны хугацаа таваас доошгүй жил байна.

2. Ахлагч нь дэд ахлагч, ахлагч, ахлах ахлагч, сургагч ахлагч, тэргүүн ахлагч цолтой байна.
**/Энэ хэсэгт 2002 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн хуулиар нэмэлт орсон/**

3. Ахлагчийн албанд дараахь хүмүүсийг авч болно:

1/ цэргийн жинхэнэ албыг 8 сараас дээш хаасан байлдагч, түрүүч;

2/ 35 хүртэлх насны нэгдүгээр зэргийн бэлтгэл үүрэгтэн;

3/ 30 хүртэлх насны эмэгтэйчүүд.

4/ гэрээт цэргийн алба хаасан байлдагч, түрүүч.
**/Энэ заалтыг 2006 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн хуулиар нэмсэн/**

## 19 дүгээр зүйл. Офицерын алба

1. Офицерын цол бүхий иргэн Монгол Улсын Зэвсэгт хүчний зохих албан тушаалд цэргийн алба хаахыг офицерын алба гэнэ.

2. Офицерыг цолоор нь дунд, ахлах, дээд гэж ангилна. Дунд офицер нь дэслэгч, ахлах дэслэгч, ахмад, ахлах офицер нь хошууч, дэд хурандаа, хурандаа, дээд офицер нь бригадын генерал, хошууч генерал, дэслэгч генерал, генерал цолтой байна.
**/Энэ хэсэгт 2006 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/**

3. Офицер, ахлагчийн цэргийн алба хаах журмыг батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.

4. Цэргийн жинхэнэ алба хаах насны дээд хязгаарт хүрсэн болон энэ хуулийн 13 дугаар зүйлийн 2-т зааснаар сунгасан хугацаа нь дууссан офицер, ахлагчийг цэргийн албанаас бэлтгэлээр халнa.

**/Энэ хэсэгт 2006 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/**

5. Офицер, ахлагчийг дараахь тохиолдолд нас харгалзахгүйгээр цэргийн жинхэнэ албанаас бэлтгэлээр халж болно:

1/ цэргийн жинхэнэ албанд биеийн эрүүл мэндээр тэнцэхгүй тухай цэргийн эмнэлгийн эмч нарын зөвлөлгөөний дүгнэлт гарсан;

2/ анги, байгууллага татан буугдсан, орон тоо нь хасагдсан, эсхүл офицер, ахлагчийн тоог цөөрүүлсэн;

3/ мэргэжил, чадварын хувьд гүйцэтгэж байгаа ажил, албан тушаалдаа тэнцэхгүй болсон;

4/ цэргийн дүрэм, сахилгыг удаа дараа зөрчсөн;
5/ гэмт хэрэг үйлдэж, хорих ял шийтгүүлсэн;
6/ ар гэрийн гачигдал, өөрийн хүсэлтээр.

## Цэргийн бэлтгэл алба

### 20 дугаар зүйл. Цэргийн бэлтгэл албанд байх нас

Цэргийн бэлтгэл албанд дээд, ахлах офицер 60 нас , дунд офицер, ахлагч 55 нас , эмэгтэй офицер, ахлагч болон байлдагч, түрүүч 50 нас хүртэл байж болно.

**/Энэ хэсгийг 2006 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/**

### 21 дүгээр зүйл. Дайчилгааны сургууль, цугларалт

1. Цэргийн бэлтгэл үүрэгтний цэрэг, техникийн бэлтгэлийг дээшлүүлэх зорилгоор тэднийг дайчилгааны сургууль, цугларалтад дараахь хугацаагаар татан оролцуулна:

1/ бэлтгэл офицерыг 5 жилд нэг удаа, цэргийн чухал мэргэжил бүхий нэгдүгээр зэргийн бэлтгэл үүрэгтнийг 3 жилд нэг удаа тус бүр нэг сар хүртэл;
2/ хоёрдугаар зэргийн бэлтгэл үүрэгтнийг бэлтгэлд байх хугацаанд нь гурван сар.

2. Байлдааны цагийн орон тоонд оногдуулан данслагдсан бэлтгэл үүрэгтнийг энэ зүйлийн 1-ийн 1-д заасан хугацаагаар цугларалтад хамруулсан эсэхийг харгалзахгүйгээр цэргийн хээрийн сургуульд татан оролцуулна.

3. Төрийн бүх шатны байгууллагын удирдах албан тушаалтны цэргийн бэлтгэл сургалтыг Засгийн газрын шийдвэрийн дагуу батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага зохион байгуулж явуулна.

4. Цэргийн бэлтгэл үүрэгтний сургалтыг Монгол Улсын Зэвсэгт хүчний Жанжин штаб зохион байгуулж явуулна.
**/Энэ хэсэгт 2002 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/**

5. Цэргийн бэлтгэл үүрэгтнийг дайчилгааны сургууль, цугларалт, хээрийн сургуульд оролцох хугацаанд түүний эрхэлж байсан ажил, албан тушаалыг үндсэн байгууллага нь хэвээр хадгалж, дундаж цалин, хөлсийг олгоно.

Дайчилгааны сургууль, цугларалт, хээрийн сургуульд оролцох хугацаанд ажиллаж байсан байгууллага нь татан буугдвал харьяалах дээд байгууллага болон тухайн байгууллагын үүргийг шилжүүлэн авсан байгууллага дээрх үүргийг хүлээнэ.

Харьяалах дээд буюу үүргийг шилжүүлэн авсан байгууллага байхгүй тохиолдолд тухайн байгууллагыг татан буулгах ажлын хэсэг уг асуудлыг шийдвэрлэнэ.

6. Цэргийн бэлтгэл үүрэгтэн дайчилгааны сургууль, цугларалт, хээрийн сургуулийн үед өвчилж, түүнийг дуустал эдгэрээгүй бол цугларалт дууссан өдрөөс эхлэн ажиллаж байсан байгууллага эрхэлсэн ажил, албан тушаалыг хэвээр хадгалж, хууль тогтоомжийн дагуу тэтгэмж олгоно.

7. Дайчилгааны сургууль, цугларалт, хээрийн сургуулиас цэргийн бэлтгэл үүрэгтнийг чөлөөлөх асуудлыг Зэвсэгт хүчний Жанжин штаб тухайн үед нь шийдвэрлэнэ.
**/Энэ хэсэгт 2002 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/**

## 22 дугаар зүйл. Цэргийн үүрэгтэнд цэргийн цол олгох

Дайчилгааны сургууль, цугларалт, хээрийн сургуульд оролцож цэргийн зохих мэргэжил эзэмшсэн цэргийн үүрэгтэнд цэргийн цол олгоно.

## Цэргийн албан хаагчийн эрх зүйн байдал

### 26 дугаар зүйл. Цэргийн албан хаагчийн эрх зүйн байдалд хамаарах хүмүүс

Цэргийн албан хаагчийн эрх зүйн байдалд:

1/ Монгол Улсын Зэвсэгт хүчний цэргийн жинхэнэ албан хаагчид;

**/Энэ заалтыг 1993 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан ба 2006 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/.**

2/ дайчилгааны сургууль, цугларалтад оролцож байгаа цэргийн үүрэгтэн тус тус хамаарна.

### 27 дугаар зүйл. Цэргийн албан хаагчийг албан үүргээ гүйцэтгэж байгаад тооцох

Цэргийн албан хаагчийн ангидаа байх, ажилдаа ирэх, харих, ангийн байрлалын гадна албан үүргээ биелүүлэхийг цэргийн албаны үүргээ гүйцэтгэж байгаад тооцно.

### 28 дугаар зүйл. Цэргийн албан хаагчийн давуу эрх, хөнгөлөлт

1. Цэргийн жинхэнэ алба хаасан хугацааг иргэний ажилласан, цэргийн албан хаагчийн тэтгэвэр тогтоох хугацаанд оруулан тооцно.

2. Тайван цагт энхийг дэмжих ажиллагаанд оролцож байгаа цэргийн албан хаагч, нисэх цагийн нормоо биелүүлсэн байлдааны сөнөөгч онгоц, байлдааны нисдэг тэрэгний нисэх бүрэлдэхүүн, хилийн суман, хороонд болон тэдэнтэй адил нөхцөлд байрлаж байгаа радио-техникийн салбарын офицер, ахлагчийн алба хааж байгаа нэг жилийг 1 жил 4 сард дүйцүүлэн тооцно.

**/Энэ хэсгийг 1997 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулса/**
**/Энэ хэсэгт 2002 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмэлт орсон/**
**/Энэ хэсэгт 2010 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/**

4. Офицер, ахлагч, гэрээт цэргийн албан хаагч жил бүр ажлын 15 өдөр, сонсогч ажлын 25 өдрийн амралтыг биеэр эдэлнэ. Замд зайлшгүй шаардагдах өдрийг амралтын хугацаанд тооцохгүй.

**/Энэ хэсэгт 1997 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн хуулиар нэмэлт орсон ба 1998 оны 10 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/**

Офицер, ахлагч нарт цэргийн жинхэнэ алба хаасан 5 жил тутамд ажлын хоёр өдрийн нэмэгдэл амралт олгоно.

5. Цэргийн анги, байгууллагын мэдлийн орон сууцанд амьдарч байгаа офицер, ахлагчийн орон сууцны хөлсийг 30 хүртэл хувиар хөнгөлнө. Хэрэв цэргийн анги, байгууллага офицер, ахлагчийг орон сууцаар хангаагүй бол орон сууцны үнэлгээт хөлсний 30 хүртэл хувьтай тэнцэх тусламжийг анги, байгууллага олгоно.

10. Хугацаат байлдагч, түрүүчийг эмнэлгийн үйлчилгээгээр төлбөргүй хангана.
**/Энэ хэсэгт 1997 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн хуулиар нэмэлт орсон/.**

Офицер, ахлагч, гэрээт цэргийн албан хаагчийн эрүүл мэндийн даатгал, эмнэлгийн үйлчилгээг Монгол Улсын Иргэний эрүүл мэндийн холбогдох хуулиар зохицуулна.
**/Энэ хэсэгт 1997 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн хуулиар өөрчлөлт орсон/.**

12. Офицер, ахлагч шилжин томилогдох, цэргийн жинхэнэ албанаас бэлтгэлээр халагдах үед түүнийг гэр бүлийн гишүүд, ачаа тээшийн хамт оршин суух газарт нь хүргэх тээврийн хэрэгслийг анги, байгууллагаас гаргах буюу зардлыг автомашин, төмөр замын үнэлгээт хөлсөөр олгоно.

13. Офицер, ахлагч өөр анги, байгууллагад шилжин алба хаах болсонтой холбогдож эхнэр /нөхөр/ нь хөдөлмөрийн гэрээ цуцлахад хүрсэн бол тэдэнд нэг сараас доошгүй хугацааны дундаж цалинтай тэнцэх тэтгэмжийг ажиллаж байсан байгууллага нь олгоно.

16. Алслагдсан цэргийн анги, салбарт ажиллаж байгаа офицер, ахлагчийн сургуулийн насны хүүхдийн боловсролыг дэмжих зорилгоор тухайн гэр бүлд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцэхүйц мөнгөн тусламжийг жилд нэг удаа олгоно. Алслагдсанд тооцох анги, салбарын жагсаалтыг Монгол Улсын Засгийн газар тогтоох бөгөөд тусламжид шаардагдах хөрөнгийг жил бүр улсын төсөвт тусгана.
**/Энэ хэсгийг 2006 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн хуулиар нэмсэн/**

## 34 дүгээр зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

Энэ хуулийг 1992 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН БАГА ХУРЛЫН**
**ДАРГА Р. ГОНЧИГДОРЖ**
**МОНГОЛ УЛСЫН БАГА ХУРЛЫН**
**НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Б. ЧИМИД**